



“BARILGA BASKETBALL-2022” САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Барилга МН-ээс барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, компаниудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “**BARILGA BASKETBALL-2022**” сагсан бөмбөгийн тэмцээн 2022 оны 03 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд “Чухаг” спорт төвийн зааланд зохион байгуулагдана.

Нэг. Тэмцээний зорилго

Барилгын салбарын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрөөх боломжийг бүрдүүлэх

Ерөнхий зохион байгуулагч: “Барилга МН”

Хамтран зохион байгуулагч: Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, Монголын барилгын үндэсний ассоциаци

Хоёр. Тэмцээний хугацаа

2022 оны 03-р сарын 19-20 ны өдрүүдэд 09:00 цагаас “Чухаг” спорт төвийн зааланд

Гурав. Хамрах хүрээ, Тавигдах шаардлага

- Барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага нь эрэгтэй, эмэгтэй гэсэн ангиллаар багаа бүрдүүлэн оролцоно. */Баг нь зөвхөн тухайн байгууллагын ажилчдаас бүрдсэн байна./*
- Тухайн багийн тоглогч нь тус байгууллагад гэрээний үндсэн дээр ажилладаг, нийгмийн даатгалын шимтгэлийг тус компанийн нэрийн өмнөөс 2 болон түүнээс дээш сараар төлсөн байх шаардлагатай.
- Зохион байгуулагчдын зүгээс тодорхой үндэслэлээр тухайн тоглогчийг тэмцээнд оролцуулахгүй гэсэн шийдвэр нь эцсийн шийдвэр байна.
- Зохион байгуулагч нь тухайн ажилтны нийгмийн даатгалын дэвтрийг шалгаж, удирдамжинд заагдсан шаардлага хангаагүй тохиолдолд тухайн тоглогчийг тэмцээнээс хасах эрхтэй.

Дөрөв. Тэмцээн зохион байгуулах журам:

1. Тэмцээний нээлт 3 сарын 19 -ны 13:00 цагт болох ба баг тамирчид тэмцээний нээлтийн ажиллагаа эхлэхээс 30 минутын өмнө өөрийн багийн туг, далбааг авч ирсэн байх
2. Оролцох баг тамирчид өөрийн байгууллагын нэрийг тодорхой бичсэн, спортын нэгдсэн хувцас, эмблем, туг, хувийн дугаартай байна.
3. Нэг баг 8 тоглогчтой байх бөгөөд 2 компани /ТББ/ хамтран баг бүрдүүлэн оролцож болно.
4. Тэмцээний удирдамж болон тухайн үед зохион байгуулагчдын зүгээс тавьсан шаардлагыг биелүүлж, ёс зүйтэй байх

5. Тэмцээний явцад тэмцээний талаар болон өөр бусад асуудлаар маргаан гаргахгүй байх, шүүгчтэй маргалдахгүй байх /Шүүгчийн гаргасан шийдвэр эцсийнх байна./
6. Баг, тамирчид өөрийн багийг дэмжихээр хүрэлцэн ирсэн хөгжөөн дэмжигчдийн зохион байгуулалтыг хариуцан аливаа зүй бус үйлдэл гаргуулахгүй байх
7. Баг, тамирчид болон хөгжөөн дэмжигчид бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох, тоглолтын үед хараал хэлэхийг хатуу хориглоно.
8. Тэмцээний үед удирдамжид заасан дэг журам болон зохион байгуулагчдын зүгээс тухайн үед тавьсан шаардлагыг биелүүлээгүй баг, тамирчдад нэг удаа сануулах арга хэмжээ авах бөгөөд дахин зөрчил гаргавал тухайн багийг тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авна.
9. Баг, тамирчид хуваарьт тоглолт болох цагтаа ирээгүй бол 5 минут хүлээх бөгөөд дээрх хугацаанд амжиж ирээгүй тохиолдолд тухайн тоглолтод хожигдсоноор тооцно.
10. Баг тамирчдын бүрдүүлэх бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн тохиолдолд тухайн багыг тэмцээнээс шууд хасна.
11. Багт дээд лигт тоглодог тамирчинг оролцуулахгүй болно.
12. Тамирчид уг байгууллагад 2 сараас дээш ажилласан байна./Нийгмийн даатгал төлсөн эсэхээр баталгаажуулна\

Тав: Мэдүүлэг хүлээн авах:

designer@barilga.mn хаягаар болон Барилга МН оффисийн байранд 2022.03.16-ны 13:00 цаг хүртэл хүлээн авна.

Мэдүүлэг ирүүлэхдээ анхаарах зүйлс:

- Багийн мэдүүлгийг хавсралт 1-ийн дагуу бүрдүүлэх /Хүснэгтээр гаргасан мэдүүлгийг зураггүй бол хүлээн авахгүй/
- Тоглогчийн иргэний үнэмлэхний хуулбар /заавал канондаж авчрах/
- Нийгмийн даатгалын дэвтрийн эх хувь, хуулбарын хамт /заавал канондаж авчрах/ эсхүл ТҮЦ машинаас авсан нийгмийн даатгалын лавлагаа
 - Нийгмийн даатгалын дэвтэрт ажилд орсон тушаал бичигдсэн байх
 - Нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөж, НД-ын тамга дарагдсан байх
 - Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй тохиолдолд ТҮЦ машинаас тоглогч бүр тодорхойлолт авсан байх

Зургаа: Бүртгэлийн хураамж:

- Баг тус бүр хураамж 600,000 төгрөг.
/Хураамжийг бэлнээр болон дансаар тушааж болно.

Данс: Хаан банк 5175011074 тоот данс, “Барилга МН”ХХК

Долоо: Шагнал:

- Эхний гурван байр
ЦОМ /аварга багт/, МЕДАЛЬ, ӨРГӨМЖЛӨЛ, МӨНГӨН ШАГНАЛ (алт, мөнгө, хүрэл)
- Эрэгтэй, эмэгтэй шилдэг тоглогч
ЦОМ, ӨРГӨМЖЛӨЛ, МӨНГӨН ШАГНАЛ

Найм. Анхааруулах зүйлс:

- Хоол, ус, ундааны хаягдлыг зориулалтын хогийн саванд хаях
- Тамхийг зөвшөөрөгдсөн газарт татах
- Архи согтууруулах ундааны зүйл хэрэглэх, хэрэглэсэн үедээ талбайд гарахыг хориглоно.
- Нийт тамирчид өөрийн солих хувцас, эд зүйлээ өөрөө хариуцна. Гээсэн, алдагдсан эд зүйлийг зохион байгуулах комисс хариуцахгүй болно.

Ес.Техникийн зөвлөгөөн:

- 2022 оны 03-р сарын 16-ны Лхагва гарагт болно.
Хаяг: БЗД 6-р хороо 21-р сургуулийн баруун урд BARILGA.MN байр 5 давхар
- Техникийн зөвлөлийн хурал дээр тэмцээний нарийвчилсан дүрмийг танилцуулж тэмцээний тоглолтын хуваарийг сугалаа сугалуулж шийднэ.

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Дэлгэрэнгүй мэдээллийг 8680-6010, 9990-7816 утсаар лавлана уу.

Хамтдаа бүтээе Хамтдаа хөгжье